

ЖАРГАЛАНТ СУМЫН 15-Р ЦЭЦЭРЛЭГИЙН 2017-2019 ОНЫ
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Шалгалтын зорилго

Ховд аймгийн Засаг даргын баталсан 35/02/11 тоот удирдамжийн дагуу Жаргалант сумын 15-р Цэцэрлэгийн 2017-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд төрийн өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтын байдал, төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэнд үнэлгээ дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, эрсдлээс урьдчилан сэргийлж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан ажиллахад оршино.

Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Ховд аймгийн Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Ж.Цэнд-Аюуш, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Н.Балт нар 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс ажлын 20 өдрийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Гурав. Шалгалтанд хамрагдсан асуудал

Жаргалант сумын 15-р Цэцэрлэгийн 2017-2019 оны санхүүгийн үйл ажиллагааг анхан шатны болон нягтлан бодох бүртгэлд үндэслэн Монгол улсын санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн болон бусад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар журмын хэрэгжилтийг анхан шатны бүртгэл, нягтлан бодох бүртгэл, үндсэн баримт материал, тайлан тэнцэлд тулгуурлан явуулав.

Дөрөв. Шалгалтанд хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл

Тус Цэцэрлэг нь 2017-2019 онд 19 багш ажилчидтай дундажаар 150 гаруй хүүхэдтэй багш ажилтаны ёс зүйн хэм хэмжээ, харилцааг сайжруулан эцэг эх олон нийтийн оролцоотой хүүхэд бүрийг хайрлан хүндэтгэж эх хэлээрээ зөв ярих ардын сурган хүмүүжүүлэх ухаанд тулгуурлан хөгжүүлнэ гэсэн зорилт тавин ажилласан байна.

2017 онд 21750 хүүхэд авч ажиллахаас 16384 хүүхэд авч хүүхэд өдрийн төлөвлөгөөг 5366 хүүхдээр таслан 73.3 хувьтай ажилласан.

2018 онд 21375 хүүхэд авч ажиллахаас 17212 хүүхэд авч хүүхэд өдрийн төлөвлөгөөг 4163 хүүхдээр таслан 80.5 хувьтай ажилласан.

2019 онд 22375 хүүхэд авч ажиллахаас 21697 хүүхэд авч хүүхэд өдрийн төлөвлөгөөг 678 хүүхдээр таслан 97 хувьтай ажилласан.

Тав. Төсвийн зарлага санхүүжилтийн талаар

2017 онд 19 орон тоотой улсын төсвөөс 160517.5 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 191021.6 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Цэцэрлэг байгуулагдсантай холбоотой тохижилтын зардалд 31000.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас нэмэлт санхүүжилтаар олгосон байна.

Зарцуулалтыг зардлын зүйл ангиар харуулбал:

№	Зардлын зүйл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Цалин хөлс	78470.3	76886.3	1583.9	97
2	НДШ	7776.5	7621.4	155.1	98
3	Бичиг хэрэг	80.3	84.6	-4.3	105
4	Гэрэл цахилгаан	1300.0	1351.3	-51.3	103
5	Түлш халаалт	10806.7	14339.7	-3533.0	132
6	Тээвэр шатахуун	2040.0	2540.0	-500.0	100
7	Шуудан холбоо	65.3	65.3	0	100
8	Цэвэр бохир ус	6065.8	4148.6	1917.1	68
9	томилолт	82.8		82.8	
10	Ном хэвлэл	45.2	44.5	0.7	98
11	Тавилга эд хогшил		23129.5	-23129.5	100
12	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн, эд зүйлс	27111.7	29141.7	-2030.0	107
13	Эд хогшил, урсгал засвар	6511.5	6237.9	273.5	95
14	Хоол хүнсний зардал	20702.7	20720.1	17.4	100
15	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	42.7	42.7	0	100
16	Аудитын баталгаажуулах зардал	223.4	195.4	28.0	87
17	Хичээл үйлдвэрийн дадлагын зардал	163.2	1419.2	-1256.0	
18	Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал	4200.0	4200.0	0	100
19	Нормын хувцас зөөлөн эдлэл	2154.1	404.0	1750.0	17
20	Бараа үйлчилгээний бусад	615.0	615.0	0	100
21	Бараа үйлчилгээний бусад зардал	451.8	451.8	0	100
	Дүн	160517.5	191021.6	30504.1	

2018 онд 19 орон тоотой улсын төсвөөс 222516.7 мянган төгрөгийн зардал гаргахаартөлөвлөж, гүйцэтгэлээр 218929.7 мянган төгрөгийн зардал гаргаж 3587.0 төгрөгийн зардлыг хэмнэж ажилласан байна.

Зарцуулалтыг зардлын зүйл ангиар харуулбал:

№	Зардлын зүйл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Цалин хөлс	123496.5	124286.2	-789.7	100.6
2	НДШ	14819.6	14819.6	0	100
3	Бичиг хэрэг	101.1	92.8	8.3	92

4	Гэрэл цахилгаан	3228.9	3000.3	228.5	92
5	Түлш халаалт	24584.9	24574.9	9,9	99,6
6	Тээвэр шатахуун	192.0	192.0	0	100
7	Шуудан холбоо	181.6	181.6	0	100
8	Ус	9461.5	8589.3	872.1	90.7
9	томилолт	101.1	101.1	0	100
10	Ном хэвлэл	55.5	55.5	0	100
11	Мэдээлэл технологийн үйлчилгээ	143.0	160.0	-17.0	111
12	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн, эд зүйлс	4179.4	4273.3	-93,9	102
14	Хоол хүнсний зардал	28981.3	27843.5	1137.8	96
15	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	52.2	52.2	0	100
16	Аудитын баталгаажуулах зардал	137.0	137.0	0	100
17	Бусад зардал	1892.2	1016.8	875.3	53
18	Хичээл үйлдвэрийн дадлагын зардал	1520.3	644.9	875.3	42
19	Бусад зардал	371.9	371.9	0	100
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	10389.6	9089.4	1300.1	87.6
21	Урсгал засвар	166.4	166.4	0	100
22	Нормын хувцас зөөлөн эдлэл	495.9	457.6	38.3	
23	Дүн	222516.7	218929.7	3586.9	98

2018 оны авлагын эхний үлдэгдэл 5.1 мянган төгрөг байсан бол 2018 онд 1083.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь НДШ авлага 107.1 мянган төгрөг ХХОАТ-н авлага 976.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

2019 онд 17 орон тоотой улсын төсвөөс 267407.8 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 267407.8 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Зарцуулалтыг зардлын зүйл ангиар харуулбал:

№	Зардлын зүйл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Цалин хөлс	159150.5	159150.5	0	100
2	НДШ	19893.8	19893.8	0	100
3	Бичиг хэрэг	91.4	57.4	34.0	62
4	Гэрэл цахилгаан	3053.5	2461.0	592.4	80
5	Түлш халаалт	26285.7	26285.7	0	100
6	Тээвэр шатахуун	61.7	61.7	0	100
7	Шуудан холбоо	75.0	192.7	-117.7	256
8	Ус	9161.5	7954.1	1207,3	86
9	томилолт	94.6	94.6	0	100
10	Ном хэвлэл	52.2	99.9	-47,7	100
11	Бага үнэтэй түргэн элэгдэх	166.4	2293.3	-2126.9	100

	ахуйн, эд зүйлс				
12	Хоол хүнсний зардал	35287.5	35113.6	173.8	99
13	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	48.9	48.9	0	100
14	Аудитын баталгаажуулах зардал	127.2	432.0	-304.8	339
15	Бусад зардал	12223.2	11930.0	293.1	97
16	Хичээл үйлдвэрийн дадлагын зардал	913.5	913.5	0	100
17	Бусад зардал	913.5	913.5	0	100
18	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	12096.0	11498.0	597.9	87.6
19	Урсгал засвар	385.1	393.6	-8.5	100
20	Нормын хувцас зөөлөн эдлэл	463.3	457.6	0	100
	Дүн	267407.8	267407.8	0	100

2019 оны авлагын эхний үлдэгдэл 1083.4 мянган төгрөг байсан оны эцэст 165.5 мянган төгрөг болон буурсан байна. Харин оны эхэнд өглөгийн үлдэгдэлгүй байсан бол тайлант оны эцэст 44.3 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Зургаа. Өмнөх шалгалтын талаар

Жаргалант сумын 15-р Цэцэрлэг нь 2017-2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан байна.

Долоо. Шалгалтаар илэрсэн ололттой талууд

Цэцэрлэгийн нийт хүүхдийг хамруулан “Бид багшдаа хайртай”, “Шинэ жил”, “Цагаансар “Хаврын баяр” өглөөлөг зохион байгуулан хүүхдийн бүтээлээр үзэсгэлэн гаргасан. Мөн цэцэрлэгийн нийт 80 гаруй хүүхдэд нийт багш ажилчид, эцэг эхийн төлөөлөлийг хамруулан 1 жилийнхээ ойн хүрээнд “Тэнгэр заяат цэцэгхэн үрс” тайлан тоглолтыг хийж орон нутгийн Ховд ТҮ-р сурталчлан ажилласан.

“Ном”, “Авьяас”, “Багшийн хөгжил” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн хагас бүтэн жилээр тайлангаа тавин олон ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Шинээр байгуулагдсантай холбоотой Улсын болон орон нутгийн санхүүжилтаар орчины тохижилт хөрөнгө тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан.

2017-2019 оны санхүүгийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авсан тайлан блансыг хуулийн хугацаанд тушааж хэвшсэн, анхан шатны баримт болон журнал бүртгэлийн эмх цэгц сайн зэрэг ололттой талууд байна.

Найм. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал

- Цэцэрлэгийн эрхлэгчид Жаргалант сумын Засаг даргын 2017 оны 06 сарын 13-ны өдрийн А/131 тоот захирамж, Аймгийн засаг даргын 2017 оны 07 сарын 17-ны өдрийн А/290 тоот захирамжийг давхардуулан ур чадварын нэмэгдэлийг 39 хувиар илүү тооцон 277.3 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт, Аймгийн засаг даргын 2017 оны 07 сарын 17-ны өдрийн А/290 тоот захирамжийг

- ТШ-2018-АЖИЛ-09/24-20 тоот гэрээний дагуу 3900.0 мянган төгрөгийн тоглоомын талбайн ажлыг Буянттэгш үйлс ХХК-нь хийж гүйцэтгэсэн ба хийгдсэн тоглоомоос 200.0 мянган төгрөгийн хүүхдийн машин, 900.0 мянган төгрөгийн саравч нь тухайн хавар нь эвдэрч ашиглахгүй байгаа ба зураг төсөвт тусгагдсан ажлаас 300.0 мянган төгрөгийн үнэтэй хүүхдийн тоглоомыг хийгээгүй байхад 2018 оны 12 сарын 17-ны өдрийн 08 тоот хүлээн авах комиссын акт үйлдэж 5-н хүний бүрэлдхүүнтэй хүлээн авсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, ТШ-2018-АЖИЛ-09/24-20 тоот гэрээний 3.1, Гэрээний тусгай нөхцөлийн 11 дахь заалтыг

- 2017 онд 8250.0 мянган төгрөгийг, 2018 онд 9880.0 мянган төгрөгийг хүүхдийн хоолны зардал, цалингийн зардалаас хэмнэж гүйлгэн тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл хангагдсан байхад дахин татсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 73 дугаар тушаалыг

- Цэцэрлэгийн эрхлэгчийн 2017 оны 08 сарын 11-ны өдрийн Б/23 тоот, 2017 оны 05 сарын 24-ны өдрийн Б/19 тоот тушаалаар 2 ажилтанд нар сахилгын шийтгэл тус тус ногдуулсан байхад төрийн албан хаагчидад олгох нэг удаагийн тэтгэмж 405.0 /202500*2/ мянган төгрөгийг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.6 дахь заалт, Улсын их хурлын 2017 оны 67 дугаар тогтоол, Засгийн газрын хуралдааны 2017 оны 12 сарын тэмдэглэлийг

- 2017 оны 9, 10 сарууд, 2019 оны 6, 10, 12 саруудад бүх албан хаагчидад хавтгайруулан ур чадварын нэмэгдэл олгосон, ур чадварын доод хэмжээ нь сарын цалингийн 10 хувь байна гэсэн заалтыг зөрчиж сарын зарим сард 5 хувиар тооцон олгосон нь Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 4-р хавсралтын 3, 5 дахь заалтуудыг

- Цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 05 сарын 29-ны А/15 тоот, 09 сарын 27-ны өдрийн А/21 тоот тушаалын хавсралтаар ур чадварын нэмэгдэлийг нягтлан бодогчид 5 хувь илүү тооцон 56086 төгрөг олгосон нь Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дугаар тушаалын хавсралт Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журамын 3-д заасан Ур чадварын нэмэгдлийн дээд хэмжээ

нь тухайн албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн 25 хувиас ихгүй байна гэснийг зөрчсөн.

- 2018 оны 12 сарын 17-нд багш ажилчидад олгосон түлшний хөнгөлөлт 789.7 төгрөгөөс НДШ 86.8 мянган төгрөг суутган тооцоогүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дахь заалтыг

- 2018 онд Цэцэрлэгийн эрхлэгчид амралт, цалинг 1 өдрөөр давхардуулан 46.4 мянган төгрөг, арга зүйчид 2018-2019 онд 4 өдрийн амралт, цалинг давхардуулж 206.3 мянган төгрөг, нийт 252.8 мянган төгрөгийг илүү тооцон олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 55 дугаар зүйлийн 55.1 дэхь заалтуудыг

- Шалгалтын явцад нэг өдрийн хүүхдийн хоолтой танилцахад Цэцэрлэгчийн Эрхлэгчийн баталсан хүүхдийн хоолны цэс зөрчиж тухайн өдрийн цай өгч байсан, зарим өдрийн хоолны материалыг урьдчилж олгодоогоос ногоо, гурил ихээхэн хэмжээгээр бэлдсэн, хүүхдийн нас хүйсд тохирохгүй зөгийн бал, чихэр, вапли зэрэг хүнсийг тушаал зөрчиж хэрэглэдэг, 2019 онд 1 хүүхдийн хоолны зардлыг 150615 төгрөгөөр буюу 7 төгрөгөөр илүү тооцон хоол зарлага болгосон, 2018 оны 05 сард 94 хүүхэд буюу 155.4 мянган төгрөгийн хоолыг тус тус илүү зарлага болгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2010 оны 206 дугаар тушаалын хавсралт, БСШУ-ны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2005 оны 225/296 тоот тушаалын заалтыг тус тус зөрчиж байна.

Ес. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Тус хууль 2015 оны 01дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж байгаа бөгөөд энэ хуультай холбоотой тус байгууллага нь батлагдсан төсөв болон санхүүгийн жилийн мэдээллийг самбараар болон цахимаар хугацаа хоцролгүй мэдээлж хэвшсэн байна.

Арав. Авсан арга хэмжээ

Шалгалтаар тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд нийт 21,617,074 төгрөгийн зөрчил илэрсэний 1,597,334 төгрөгийг улсын байцаагчийн актаар төлүүлэхээр 20,019,740 төгрөгийг хугацаатай үүрэг арилгахаар шийдвэрлэв.

Шалгалтын хугацаанд ажилтан албан хаагчдаас гомдол, санал хүсэлт ирээгүй байна.

Арван нэг. Дүгнэлт

Тухайн байгууллагад хөтлөгдөж буй НББ болон өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт хэвийн хэмжээнд явагдаж, тайлан балансыг хуулийн хугацаанд гаргаж, зохих байгууллагуудад хянуулан баталгаажуулсан байна.

Хоол үйлдвэрийн технологийн карт хөтлөж байгаа боловч няравын ажил хангалтгүй, зэс зөрчих, хүүхдийн хоолны нормыг барьж ажиллаагүй байна.

Хөрөнгө оруулалтаар хийгдсэн хүүхдийн тоглоомын талбай дутуу хийгдсэн, эвдэрсэн, агуулах барьсан ажил чанаргүй, хөнжил гудас чанрын шаардлага хангаагүй, зарим бараа материал зах зээлийн үнээс дээгүүр үнэтэй нийлүүлсэн байна.

Арван хоёр. Цаашид авах арга хэмжээний санал:

Жаргалант сумын 15-р цэцэрлэгт:

1. Цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч нарт олгох цалингийн нэмэгдэл болон бусад нэмэгдлийг хууль эрх зүйн хүрээнд олгож хэвших.
2. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх талаар дорвитой ажил зохион байгуулж, Шилэн дансны нэгдсэн системд оруулах ёстой хуульд заасан /23-26төрлийн/ мэдээллүүдийг сар бүр мэдээлж хэвших.
3. Хүүхдийн нас хүйс норм нормативд таарсан хоол хүнсийг олгох ба тогооч эрхлэгчийн баталсан цэсний дагуу хоол хийж байх, нярав цэсний дагуу хүүхдийн тоонд тохируулж, өдөр бүрээр хоолны материалыг олгож хэвших.
4. Зарим төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл цалин олгохдоо хууль эрх зүйд заасан хувь хэмжээнд нийцүүлж олгох.
5. Хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажилд Цэцэрлэгийн зүгээс тавих хяналтыг сайжруулж чанаргүй дутуу тохиолдолд хүлээн авахгүй байх.
6. Зах зээлийн жишиг үнийг барьж ажиллах.
7. Зардал хооронд хууль журам зөрчиж гүйлгэн зарцуулахгүй байх.
8. Шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж, зөрчлийг арилгах талаар хийсэн ажлын тайлан, актын биелэлтийг албан бичгээр 2020 оны 04 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхийг даалгав.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА